



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/216

Сүхбаатар сум

Аялал жуулчлалын хөдөлгөөнийг түр хязгаарлаж,
замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "а", "в", "л" Автозамын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 12.1.8, 31 дүгээр зүйлийн 31.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5, 9.4.6, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 161 тоот тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийг хаах, замын чиглэл өөрчлөх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар сумын Хонгорморьт 1 дүгээр багийн нутаг дэвсгэр дэх хатуу хучилттай замын төгсгөлөөс Сайханы хөтөл хүртэлх шороон замыг хатуу хучилттай болгох замын ажил эхэлсэнтэй холбогдуулан иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тус хэсгийн замын хөдөлгөөнийг түр хугацаагаар хаасугай.

2. Зам хаасантай холбогдуулан гаргасан туслах замаар албаны ажил үүргээ гүйцэтгэж буй алба хаагчдыг нэвтрүүлж, иргэдийг аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор аялал, амралтын журмаар зорчиж буй иргэдийг нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Сүхбаатар сумын Засаг дарга Т.Гантулга, "Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-д тус тус даалгасугай.

3. Авто замын зорчих хэсгийг хаасантай холбогдуулан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, хяналт тавин, зохицуулалт хийж гэмт хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ж.Сайнцог/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ

